



ДУАГ



ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Дундговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ҮАГ-ГАГ/2016/06-ГА/



Санхүүжилтийн эх үүсвэр



- Ажиллагсадтай холбогдсон зардал
- Бараа үйлчилгээний бусад зардал
- Татаас ба урсгал шилжүүлэг
- Хөрөнгийн зардал

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь давуулан биелүүлж, нэр төрлөөр 5 орлого тасарсан байна.

Мандалговь
2016 он
Мандалговь
2016 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Тэргүүлэх аудитор Т.ОЮУНЧИМЭГ	Бүлэг 1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь давуулан биелүүлж, нэр төрлөөр 5 орлого тасарсан байна.	
Аудитын менежер Б.ГАНТУЯА	1.1 Дээд шатны төсвөөс 675.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна	5-6
Шинжээч Ч.БЭРХСАЙХАН	1.2 Нийт орлого 16.2 хувиар давж биелсэн ч 5 нэр төрлийн орлого 158.7 сая төгрөгөөр тасарсан байна.	6-8
Шинжээч Т.ЭНХНАРАН	Бүлэг 2 Зардлыг бүлэг хооронд шилжүүлэн тодотгож, зардлын зүйлийн хувьд хэтрэлт гараагүй байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	2.1 Батлагдсан төсвөөс 12.3 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд шилжүүлэн тодотгосон байна	9
	2.2 Орон нутгийн төсвийн зардал зүйл бүрээр 83 - 99 хувийн гүйцэтгэлтэй байна	10-11
	Дүгнэлт	12
	Зөвлөмж	12
	Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал тайлбар	13
	Тайлан баталгаажуулах тушаал	14-15
	Тайлангийн хавсралтууд	16-23
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот		
2016 оны 5 дугаар сар		

ТОВЧИЛСОН ҮГС

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИОТТХ	Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
УБ	Улаанбаатар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Дундговь аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Дундговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2015 оны Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгөхөд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийсэн. Үүнд:

- ❖ Төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
- ❖ Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл

Аоаеòàä àèèäèàñàí ø àèäóóð çççëýëò: Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур, эх сурвалж болгон ашиглав.

- Аоаеòàä í í èí í Óëñúí ñààí ääðò,
- Óðèéí õýí àèò ø àèäèèòúí ñààí ääðò,
- Óðèéí аоаеòàä í òóðàé òóóëü,
- Í ýäèèàí àí àí õ áçðòäýèèéí òóðàé òóóëü,
- Óñàèéí òóðàé òóóëü,
- 2015 оны төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр аадаа àæèè, үйлчилгээ òáàèèààí àààò òóðàé òóóëü,
- Аоñàä õí èàí ääí õ ýðò ççéí àèòóóä.

Аудитын хамрах хүрээ: Дундговь аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2015 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, төсөвт хийсэн тодотгол, Татварын хэлтсийн татварын орлогын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, холбогдох бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй: Аудитын Олон улсын стандарт, АДБОУС, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг мөрдөж, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэн, нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын хугацаа, багийн бүрэлдэхүүн: Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлын чанарын хяналтыг Аудитын менежер Б.Гантуяа хийж, гүйцэтгэлийн аудитын багийн шинжээч Ч.Бэрхсайхан, Т.Энхнаран нар 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийг аоóòàèè гүйцэтгэлээ.

Бүлэг 1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь давуулан биелүүлж, нэр төрлөөр 5 орлого тасарсан байна.

1.1 Дээд шатны төсвөөс 675.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна

УИХ-ын 2014 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр баталсан МУ-ын 2015 оны Төсвийн тухай хуульд Дундговь аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 7,772.9 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 7,313.2 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 21,113.7 сая төгрөгөөр тус тус баталж тайлант онд Төсвийн тухай хуульд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. /сая төгрөгөөр/

№	Эх үүсвэрийн нэр	УИХ-ын анх батлагдсан 2014.11.14	УИХ-ын 2015.01.23	УИХ-ын 2015.10.30
1	ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг	7,313.2	4,567.0	4,581.4
2	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	7,772.9	8,110.7	8,019.7
3	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	21,113.7	21,086.8	20,833.5
	Дүн	36,199.8	33,764.5	33,434.6

1. УИХ-ын 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 2,746.2 сая төгрөгөөр, тусгай шилжүүлгийн орлогыг 26.9 сая төгрөгөөр тус тус бууруулж, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 337.8 сая төгрөгөөр нэмж,
2. УИХ-ын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөр орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 14.4 сая төгрөгөөр нэмж, тусгай шилжүүлгийн орлогыг 253.3 сая төгрөгөөр, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 91.0 сая төгрөгөөр тус тус бууруулан тодотгосон байна.

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4,581.4 сая төгрөгийн санхүүжилт авахаас гүйцэтгэлээр 3,777.8 сая төгрөг, Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 8,019.7 сая төгрөгийн санхүүжилт авахаас 7,549.5 сая төгрөг авч 470.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу, Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр 20,833.5 сая төгрөгийн санхүүжилт авахаас 20,628.4 сая төгрөг авч 205.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу, нийт дээд шатны байгууллагаас 675.3 сая төгрөгийн дутуу санхүүжилт авсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн нийт орлогыг анх 4,159.5 сая төгрөгөөр баталж, төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулжээ. /хүснэгт 2/

№		Хүснэгт 2 /сая төгрөгөөр/		
		2014.12.05	2015.02.24	2015.12.03
1	Орлого	4,159.5	4,017.1	4,145.1

ИТХ-ын 2015 оны 02 сарын 24-ний өдрийн 01 дугаар тогтоолоор нийт орлогыг 142.4 сая төгрөгөөр бууруулж 4,017.1 сая төгрөг, 2015 оны 12 сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор орлогыг 128.0 сая төгрөгөөр нэмж 4,145.1 сая төгрөг болгон тус тус тодотгосон байна.

Санхүүжилт

Тайлант онд улс, орон нутгийн төсвөөс нийт 35,584.2 сая төгрөгийн санхүүжилт авахаас, гүйцэтгэлээр 34,474.9 сая төгрөг авч, 220.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, Улсын төсвөөс 205.1 сая төгрөгийн дутуу санхүүжилт авч, орон нутгийн төсөвт 904.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг төрлөөр харуулбал:

- Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр 20,833.5 сая төгрөгийн санхүүжилт авахаас 20,628.4 сая төгрөг авч, 47.5 сая төгрөгийг төвлөрүүлж, 205.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу,
- Орон нутгийн төсвөөс 14,750.7 сая төгрөгийн санхүүжилт авахаас 13,846.5 сая төгрөг авч, 173.1 сая төгрөгийг төвлөрүүлж, 904.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

1.2 Нийт орлого 16.2 хувиар давж биелсэн ч 5 нэр төрлийн орлого 158.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2015 оны орлогын төлөвлөгөөг 3,994.3 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 4,642.9 сая төгрөг төвлөрүүлж, 648.6 сая төгрөгөөр буюу 16.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн ч нэр төрлөөр авч үзвэл зарим татварын орлого тасарсан байна. Тухайлбал:

- ❖ Дуудлага худалдаа сонгон шалгаруулалтын орлогыг 100.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 27.3 сая төгрөг төвлөрүүлж, 72.7 сая төгрөг буюу 72.7 хувиар тасарсан байна. Төлөвлөгөө тасарсан шалтгаан нь Дундговь аймгийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 142,097.0 м² газар дуудлага худалдаагаар олгохоор төлөвлөснөөс 20,342.0 м² газар олгож 121,755.0 м² газрын дуудлага худалдааг зохион байгуулаагүйтэй холбоотой байна.
- ❖ Газрын төлбөрийн орлогыг 164.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 144.7 сая төгрөг бүрдүүлсэн нь төлөвлөгөөнөөс 19.7 сая төгрөгөөр буюу 11.9 хувиар

- дутуу байна. Хуульд заасан газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн хийдэггүй нь орлогын төлөвлөгөө биелэхгүй байх шалтгаан болжээ.
- ❖ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 51.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 11.0 сая төгрөг бүрдүүлсэн нь 40.7 сая төгрөг буюу 78.7 хувиар төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь Аймаг сумын засаг дарга нар ИТХ-ын тогтоолоор баталсан аргачлалд үндэслэн, Хог хаягдлын тухай хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.
 - ❖ Авто замын хураамжийн орлогыг 31.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 25.7 сая төгрөг төвлөрүүлж, 5.8 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь 2015 оноос эхлэн УБ хотын дугаартай тээврийн хэрэгслийн албан татвар, агаарын бохирдол, автозамын хураамжийг тухайн харьяалах татварын газар хэлтэс рүү төвлөрүүлдэг болсонтой холбоотой байна.
 - ❖ Хөрөнгө борлуулсны орлогыг 138.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 118.2 сая төгрөг бүрдүүлсэн нь 19.8 сая төгрөг буюу 14.3 хувиар төлөвлөгөө тасарсан байна. 2015 онд ИТХ-ын тогтоолоор 5 нэр төрлийн нийт 60 хөрөнгийг 84.7 сая төгрөгөөр худалдахаар шийдвэрлэсэн боловч 5 нэр төрлийн 33 хөрөнгийг 58.3 сая төгрөгөөр худалдаж, 4 нэр төрлийн 27 хөрөнгийг худалдаагүй байна. (Хавсралт №1). Энэ талаар аймгийн ОНӨА-аас тодруулахад дуудлага худалдаа явуулахаар зарласан боловч оролцогч ирээгүйгээс зохион байгуулагдаагүй гэсэн тайлбарыг өгсөн.

Тайлант оны орлогын төлөвлөгөөний биелэлтийг сум тус бүрээр авч үзэхэд Цагаандэлгэр, Сайхан-Овоо сумаас бусад сумдын орлогын төлөвлөгөө дунджаар 41.7 хувиар давж биелсэн байна.

Цагаандэлгэр сумын татварын орлого 1.5 сая төгрөг буюу 14 хувиар тасарсан, Үүнд:

1. Бууны албан татварын орлогыг 0.124 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 0.118 сая төгрөг төвлөрч, 0.006 сая төгрөг буюу 5 хувиар тасарсан
2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 0.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 0.3 сая төгрөг төвлөрч 0.4 сая төгрөг буюу 57.1 хувиар тасарсан байна. Хог хаягдлын тухай хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс тус орлого тасарсан,
3. Хүү торгуулийн орлогыг 1.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 0.5 сая төгрөг бүрдүүлж 0.7 сая төгрөг буюу 58.3 хувиар тасарсан,
4. Бусад орлогыг 1.0 сая төгрөгөөр төлөвлөж, орлого нийт дүнгээр тасарсан байна

Сайхан-Овоо сумын татварын орлого 1.9 сая төгрөг буюу 13 хувиар тасарсан, Үүнд:

1. Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 1.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 0.9 сая төгрөг төвлөрч, 0.6 сая мянган төгрөг буюу 40 хувиар тасарсан,

2. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 1.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 0.3 сая төгрөг төвлөрч, 0.7 сая төгрөг буюу 70 хувиар тасарсан байна. Энэ нь тус суманд тогтмол үйл ажиллагаа явуулдаг лицензтэй байгууллага байдаггүйтэй холбоотой,
3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 0.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 0.3 сая төгрөг тайлагнасан нь 0.6 сая төгрөг буюу 67 хувиар тасарсан байна. Хог хаягдлын тухай хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс тус орлого тасарсан,
4. Хүү торгуулийн орлогыг 1.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 0.6 сая төгрөг бүрдүүлж 1.1 сая төгрөг буюу 65 хувиар тасарсан,
5. Бусад орлогыг 1.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 0.7 сая төгрөг бүрдүүлсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 0.3 сая төгрөг буюу 30 хувиар тасарсан байна.

Хүснэгт 3

№	Тасарсан орлогын төрөл	Хүснэгт 3		Өлзийт, Эрдэнэдалай, Адаацаг сумаас бусад 12 сумдын зарим нэр төрлийн орлого тасарсан байна. Тухайлбал: 2014 онд дээрх сумдад 7 нэр төрлийн орлого 66.1 сая төгрөгөөр тасарсан бол 2015 онд 9 нэр төрлийн орлого 69.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. /Хавсралт3/
		2014 Тасарсан дүн	2015 Тасарсан дүн	
1	Буу	0.2	0.1	
2	Жишиг	0.3	0.7	
3	ИОТТХ	10.0	1.9	
4	Патент	34.8	2.6	
5	Түгээмэл тархац	16.3	6.2	
6	Улсын тэмдэгтийн	0.2	0.8	
7	Хүү торгууль	4.3	10.9	
8	Хог хаягдлын үйлчилгээ	-	41.0	
9	Бусад	-	5.0	
Нийт дүн		66.1	69.2	

Сумдад жил бүр тасарч байгаа дээрх нэр төрлийн орлогуудад дүгнэлт хийж цаашид орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэхэд анхаарч ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмж өгч ажиллаа.

Тусгай шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө 150.9 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 147.7 сая төгрөгийг төвлөрүүлж, 3.2 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь Сайнцагаан сумын 4 дүгээр сургуулийн /математикийн гүнзгийрүүлсэн сургалттай/ сургалтын төлбөр бүрэн ороогүй, бусад сумын хувьд түрээсийн орлого дутуу, эх үүсвэр бага зэргээс шалтгаалсан байна. Дэлгэрэнгүй судалгааг Хавсралт №3-т орууллаа.

Бүлэг 2. Зардлыг бүлэг хооронд шилжүүлэн тодотгож, зардлын зүйлийн хувьд хэтрэлт гараагүй байна.

2.1 Батлагдсан төсвөөс 12.3 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд шилжүүлэн тодотгосон байна

ИТХ-ын 2014 оны 12 сарын 05-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор төсвийн зарлагыг 40,372.7 сая төгрөгөөр баталж, 2015 оны 02 сарын 24-ны өдрийн 01 дугаар тогтоолоор 2,449.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 42,821.9 сая, 2015 оны 12 сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор 56.1 сая төгрөгөөр бууруулж 42,765.8 сая төгрөг болгож тус тус тодотгожээ. /Хүснэгт 3/

Хүснэгт 4 /сая төгрөгөөр/

№	2014.12.05	2015.02.24	2015.12.03
1 Зарлага	40,372.7	42,821.9	42,765.8

Тодотголоор нийт зардлын дүнд өөрчлөлт орсноос гадна зардал бүлэг хооронд өөрчлөлтүүд хийгдсэн байна. Анх батлагдсан зардлыг хамгийн сүүлийн тодотгосон төсөвтэй харьцуулалт хийлээ. /Хүснэгт 5/

Хүснэгт 5 /сая төгрөгөөр/

	Анх батлагдсанаас нэмэгдүүлж өөрчлөгдсөн зардлын бүлэг		Анх батлагдсанаас буурч өөрчлөгдсөн зардлын бүлэг		Тодотголоор өөрчлөлт орсон зардлын бүлэг	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа үйлчилгээний зардлын бүлэгт	5	0.4	4	-5.1	9	5.5
Урсгал шилжүүлгийн зардлын бүлэгт	1	4.6		-	1	4.6
Хөрөнгийн зардлын бүлэгт	1	2.3		-	1	2.3
Нийт зардал	7	7.3	4	-5.1	11	12.3

Анх батлагдсан төсвөөс бараа үйлчилгээний зардлын 5 бүлгийн зардал 0.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 4 бүлгийн зардал 5.1 сая төгрөгөөр буурч нийт 9 бүлгийн зардалд 5.5 сая төгрөгийн өөрчлөлт оржээ.

Төсөвт хүндрэл учирсантай холбоотой тусгай зориулалтын шилжүүлгийн зардлыг 241.7 сая төгрөгөөр бууруулж тодотгосон, 9 дүгээр сараас эхлэн санхүүжилтийг дутуу олгож нийт 205.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй зэрэг нь нийт төсвийг бууруулах, зардал хооронд шилжүүлэн тодотгол хийх шалтгаан болсон байна.

2.2 Орон нутгийн төсвийн зардал зүйл бүрээр 83 - 99 хувийн гүйцэтгэлтэй, хэтрэлтгүй байна.


Тайлант онд нийт зардлыг 42,765.8 сая төгрөгөөр төлөвлөж, 39,770.2 сая төгрөг буюу 93.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Судалгаанаас харахад татаас ба урсгал шилжүүлгийн зардал, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 83-84 хувь байна. /Хүснэгт 6/

Хүснэгт 6 /сая төгрөгөөр/

№	Нийт зардал	2015 он				
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь	Эзлэх хувь
1	Ажиллагсадтай холбогдсон зардал	20,529.8	20,298.0	231.8	99%	51%
2	Бараа үйлчилгээний бусад зардал	6,397.1	6,267.8	129.3	98%	16%
3	Татаас ба урсгал шилжүүлэг	5,902.6	4,980.9	921.7	84%	13%
4	Хөрөнгийн зардал	9,936.2	8,223.5	1,712.7	83%	21%
Нийт дүн		42,765.8	39,770.2	2,995.5	93%	

Нийт зардлын бүтцийг диаграммаар харуулбал:

Нийт зардлын 51.0 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 16.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 21.0 хувийг хөрөнгийн зардал, 12.0 хувийг татаас болон урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.



Төсвийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал төлөвлөгөө 4,456.7 сая төгрөгөөр буурч, гүйцэтгэл 179.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. /Хүснэгт 7 /

Хүснэгт 7 /сая төгрөгөөр/

№	Урсгал зардал	2014 он		2015 он		2014-2015 оны өөрчлөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Ажиллагсадтай холбогдсон зардал	18,656.0	18,581.4	20,529.8	20,298.0	1,873.8	1,716.6
2	Бараа үйлчилгээний бусад зардал	6,817.0	6,680.1	6,397.1	6,267.8	(419.9)	(412.3)
3	Татаас ба урсгал шилжүүлэг	6,752.9	5,102.2	5,902.6	4,980.9	(850.3)	(121.3)
4	Хөрөнгийн зардал	14,996.5	9,226.7	9,936.2	8,223.5	(5,060.3)	(1,003.2)
Нийт дүн		47,222.4	39,590.4	42,765.7	39,770.2	(4,456.7)	179.8

Нийт зардлын дүнд ажиллагсадтай холбоотой зардлын эзлэх хувь 4.1 хувиар өсч, хөрөнгийн зардлын эзлэх хувь 2.6 хувиар буурсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг нэр төрлөөр бүртгэн, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, тайлагнажээ.

Нэмэлт санхүүжилтийн данс 2015 оны эхэнд 85.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 878.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 945.9 сая төгрөгийг зарцуулж, 18.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны эх үүсвэрийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

№	Нэмэлт төсвийн эх үүсвэр	Хүснэгт 8 /сая төгрөгөөр/		
		2014 он	2015 он	Өсөлт/ (Бууралт)
1	Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	941.8	9.8	-932.0
2	Засгийн газрын нөөц хөрөнгө, ЗДН хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө	96.9	64.8	(32.1)
3	Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид	502.7	694.2	191.4
4	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	69.2	79.5	10.3
5	Төсвийн урамшуулал	15.8	30.6	14.7
Дүн		1,626.4	878.9	(747.6)

Судалгаанаас харахад санхүүжилт урьд оноос 747.6 сая төгрөгөөр буурсан байна.

Нэмэлт төсвийн зарцуулалтыг диаграммаар харуулбал:

Нийт зардлын 78.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 11.0 хувийг ажиллагсадтай холбогдсон зардалд, 11.0 хувийг татаас урсгал шилжүүлгийн зардалд тус тус зарцуулжээ.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Дээд шатны төсвөөс 675.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна
2. Нийт орлого 16.2 хувиар давж биелсэн ч 5 нэр төрлийн орлого 158.7 сая төгрөгөөр тасарсан байна.
3. Батлагдсан төсвөөс 12.3 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд шилжүүлэн тодотгосон байна.
4. Орон нутгийн төсвийн зардал зүйл бүрээр 83 - 99 хувийн гүйцэтгэлтэй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

1. Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт, газрын төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж, хөрөнгө борлуулсан, автозамын хураамжийн орлого зэрэг тайлант онд тасарсан орлогуудад дүгнэлт хийж цаашид орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэхэд анхаарч ажиллахыг зөвлөж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ШИНЖЭЭЧ

Ч.БЭРХСАЙХАН

ШИНЖЭЭЧ

Т.ЭНХНАРАН

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заагдсан зөвхөн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төсөлд санал тайлбар авахаар аймгийн Засаг даргад хүргүүлсэн боловч заасан хугацаанд хариу ирүүлээгүй тул санал тайлбаргүй гэж үзлээ.

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 5 сарын 13 өдөр

Дугаар А/10

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, Гүйцэтгэлийн шалгалтын журмын 23 дугаар зүйлийн 2, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Дундговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2015 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ҮАГ-ГАГ/2016/06-ГА/-г баталсугай.

Хоёр. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. "Дундговь аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2015 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэст тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнгийн талаар 2016 оны 06 дугаар сарын 20-ны дотор Аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Од-Эрдэнэ/-д зөвлөсүгэй.


Тав. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2016 оны 3 дугаар улиралд гарган танилцуулахыг Аудитын менежер /Б.Гантуяа/, Гүйцэтгэлийн аудитын багийн шинжээч /Ч.Бэрхсайхан/ нарт үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ОЮУНЧИМЭГ



D:\office\Tushaal\tushaal 2016\batalgaajuulah TGNT.doc

0900000024


 Дундговь аймгийн Аудитын газрын
 тэргүүлэх аудиторын 2016 оны 5- дугаар сарын
 13- ны өдрийн АИО дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд хийсэн гүйцэтгэлийн
 аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсөн хуулийн заалт	Зөрчлийн дүн мян.лөг	Үүнээс			Үр өгөөжийн	
				Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Тоо
1	Тайлант онд тасарсан дуудлага худалдаа сонгон шалгаруулалтын орлого, газрын төлбөрийн орлого, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого, хөрөнгө борлуулсаны орлого, автозамын хураамжийн орлогод дүгнэлт хийж цаашид орлогыг нэр төрлөөр таслахгүй байх тал дээр анхаарч ажиллах	Төсвийн тухай хуулийн 31.4.1, Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4, 6.1.2, Газрын төлбөрийн тухай хуулийн 6.1.1, 6.1.2, 7.1.4, Газрын тухай хуулийн 13.1				158.7	1	158.7

АУДИТЫН ГАЗАР

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Хавсралт №1

ОРОН НУТГИЙН ОРЛОГО ТУЛГАЛТ

/сая төгрөгөөр/

ОРЛОГЫН ТӨРӨЛ	Жилийн төлөвлөгөө	ӨССӨН				Нэгтгэсэн тайлангаар	Зөрүү	Тайлбар
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	(Давсан)/ Тасарсан	Хувь			
I Орон нутгийн орлого	3,994.1	3,994.2	4,642.9	(648.7)	16%	4,576.0	66.9	
Сумын төвлөрсөн	737.9	737.9	1,258.7	(520.7)	71%	1,191.8	66.9	
ИОТТХ	172.5	172.5	234.2	(61.7)	36%	330.4	0.1	ноос, арьс ширний урамшуулал орж ирсэн
Жишиг	17.0	17.0	16.9	0.1	#DIV/0!			
Патент	80.7	80.7	79.3	1.4	-2%			патентын орлогын 85,8 хувьд нь Хулд сумын бичил уурхайгаас бүрддэг бөгөөд уг уурхайн үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар үйл ажиллагааг нь зогсоосон.
Буу	2.6	2.6	2.7	(0.2)	7%	2.7	-	
Улсын тэмдэгтийн	69.0	69.0	101.5	(32.5)	47%	101.5	-	
Хог хаягдлын үйлчилгээ	51.7	51.7	11.0	40.7	-79%	11.0	-	2014 оны Аймгийн иргэдийн хурлаас баталсан 55-р тогтоолын дагуу сумдын засаг дарга нарт үүрэг болгосон боловч биелээгүй
Түгээмэл тархац	38.4	38.4	38.4	(0.0)	0%	38.4	-	Тус орлого 6 суманд тасарсан.
Ангийн зөвшөөрөл	-	-	55.2	(55.2)	#DIV/0!	55.2	-	2 шонхор шувуу агнах зөвшөөрлийн төлбөр төвлөрүүлсэн.

1.3	Татварын бус	306.1	306.1	719.3	(413.2)	135%	652.6	66.8	
Үүнээс	Хүү торгууль	142.8	142.8	455.9	(313.1)	219%	154.0	301.9	
	Төсвийн өөрийн орлого	77.3	77.3	150.0	(72.7)	94%	328.8	(178.8)	
III	Бусад	86.0	86.0	113.5	(27.4)	32%	169.8	(56.3)	
Аймгийн төвлөрсөн		3,256.2	3,256.3	3,384.3	(128.0)	4%	3,384.3	-	
	Цалин	2,880.2	2,880.2	3,118.2	(238.0)	8%	3,118.2	-	
	Буцаан олголт	(348.2)	(348.2)	(348.2)	-	0%	(348.2)	-	
	Авто тээврийн	181.4	181.4	182.2	(0.8)	0%	182.2	-	
	Үл хөдлөх хөрөнгийн	75.0	75.0	82.2	(7.2)	10%	82.2	-	
	Газар	164.4	164.4	144.6	19.8	-12%	144.6	-	АИТХурлаар 37600.0 мянган төгрөгөөр нэмж тодотгосон боловч биелээгүй.
	Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	100.0	100.0	27.3	72.7	-73%	27.3	-	АИТХурлаар 100000.0 мянган төгрөгөөр нэмж баталсан ч биелээгүй.
	ҮХХ борлуулсны	138.0	138.0	118.2	19.9	-14%	118.2	-	
	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	34.0	34.0	34.1	(0.1)	0%	34.1	-	
	Авто замын хураамж	31.5	31.5	25.7	5.8	-18%	25.7	-	АИТХурлаар 6500.0 мянган төгрөгөөр нэмж баталсан. 2015 оноос эхлэн УБ дугаартай тээврийн хэрэгслийн албан татвар , агаарын бохирдол, автозамын хураамжийг тухайн харъяалах татварын газар хэлтэс рүү төвлөрүүлдэг болсон. Дан аймгийн / ДУА/ дугаартай тээврийн хэрэгслийн автозамын хураамжийг төвлөрүүлсэн.

Хавсралт №2

ДУНДГОВЬ АЙМГИЙН СУМДЫН ТАТВАРЫН МЭДЭЭНИЙ НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Давсан/Тасарсан	%	Тасарсан орлогын төрөл	Тасарсан орлогын дүн	Тасарсан орлогын шалтгаан
1	Дэлгэрцогт	19,476.0	21,569.1	2,093.1	11%	Хог хаягдлын үйлчилгээ	951.9	2014 оны Аймгийн иргэдийн хурлаас баталсан 55-р тогтоолын дагуу сумдын засаг дарга нарт үүрэг болгосон боловч биелээгүй
						Түгээмэл тархац	1,500.0	Зам ангийн ажил зогссонтой холбоотой
						Хүү торгууль	644.9	2015 оны 7 сараас эхлэн татварын хяналт шалгалт хийгдээгүй.
2	Дэрэн	18,334.0	44,405.3	26,071.3	142%	Бусад	960.00	
						Хүү торгууль	1,398.50	2015 оны 7 сараас эхлэн татварын хяналт шалгалт хийгдээгүй.
	Говь-Угтаал	28,560.0	47,412.9	18,852.9	66%	Буу	12.0	Төлөвлөгөө ногдлоос илүү ирсэн
4	Цагаандэлгэр	10,824.0	9,284.3	- 1,539.7	-14%	Бууны албан татвар	6.0	Бууны албан татварын гүйцэтгэлд иргэд шилжихдээ буугаа авч шилждэггүй байдал нөлөөлж байна.
						Хог хаягдлын үйлчилгээ	483.0	Хог хаягдлын үйлчилгээний гүйцэтгэлд төлөвлөгөөг батлахдаа орон нутгаас санал авдаггүй, зарим нэр төрөл дээр бодит бус төлөвлөгдсөнтэй холбоотой байна.
						Хүү торгууль	654.8	Хүү торгуулийн орлого нь татварын хүү торгууль, иргэний бүртгэлийн торгууль, цагдаагийн байгууллагын торгуулиас бүрддэг учир энэ орлогын гүйцэтгэлд хүн ам цөөн, хэрэг зөрчил бага гардаг байдал холбоотой байна.
						Бусад	1,000.0	Бусад орлогын төлөвлөгөө тасарсан нь орлогын эх үүсвэр муу, хүн ам харьцангуй цөөнтэй холбоотой байна.

5	Баянжаргалан	20,196.00	22,551.1	2,355.1	12%	Түгээмэл тархац	1,503.0	Тайлант онд байгалийн баялаг ашигласан өдөр, тус орлогын бүрдүүлэлт нь халуун усны барилгыг барьсан компаниас оруулсан орлого байна.
						Хүү торгууль	2,649.9	Хүү торгуулийн орлого нь татварын хүү торгууль, иргэний бүртгэлийн торгууль, цагдаагийн байгууллагын торгуулиас бүрдсэн байна.
						Бусад	1,647.6	Эх үүсвэр бага
6	Өндөршил	19,246.0	23,279.1	4,033.1	21%	Улсын тэмдэгтийн	266.9	
						Түгээмэл тархац	500.0	Тайлант онд байгалийн баялаг ашигласан өдөр, тус орлогын бүрдүүлэлт нь халуун усны барилгыг барьсан компаниас оруулсан орлого байна.
						Хүү торгууль	1,374.0	2015 оны 7 сараас эхлэн татварын хяналт шалгалт хийгдээгүй.
						Бусад	444.6	
7	Гурвансайхан	74,750.0	86,039.3	11,289.3	15%	Буу	40.0	жил бүр төлөвлөгөө нэмэгдэж байгаагаас
						Хүү торгууль	665.0	жил бүр төлөвлөгөө нэмэгдэж байгаагаас
8	Өлзийт	34,348.0	44,952.8	10,604.8	31%			Тасарсан орлого байхгүй
9	Хулд	68,653.7	82,245.8	13,592.1	20%	ИОТТХ	1,962.4	Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газрын шийдвэрээр 7 сарын турш Бичил уурхайн үйл ажиллагаа хаалттай байсан.
						Хог хаягдлын үйлчилгээ	313.5	Аймаг сумын ИТХ, Засаг дарга нар Хог хаягдлын тухай хуулинд заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй
10	Луус	16,030.0	23,605.0	7,575.0	47%	Бууны албан татвар	22.0	Шилжилт хөдөлгөөн ихтэй, орлого орох үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж дутмаг
						Хог хаягдлын үйлчилгээ	790.0	2014 оны Аймгийн иргэдийн хурлаас баталсан 55-р тогтоолын дагуу сумдын засаг дарга нарт үүрэг болгосон боловч биелээгүй

						Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	643.2	Барилга байгууламж баригдадгүй учир орлого сүүлийн жилүүдэд тасраад байна.
						Хүү торгууль	661.0	Эх үүсвэр бага
11	Дэлгэрхангай	15,160.0	20,720.5	5,560.45	37%	Хог хаягдлын үйлчилгээ	570.0	Хог хаягдлын хураамжийн тухай журмыг ИТХ-аар батлуулаагүй байсан тул хураамж хураах эрх зүйн үндэсгүй, тогтоосон хэмжээ байгаагүй учир төлөвлөгөөндөө хүрээгүй.
						Түгээмэл тархац	1,380.0	Тус суманд баригдаж буй 2 барилгатай учир төлөвлөгөө өндөр тавигдаж ирсэн . нэг барилга нь зогсонги байдалд орсон, цэцэрлэгийн барилгыг барьж буй компанид мэдэгдэх хуудас хүргүүлсэн ч барилга нь дуусаагүй байгаа учир төлбөр нь хийгдээгүй.
						Хүү торгууль	95.6	сумын холбогдох байгууллагууд ын орлого боломжит хэмжээгээр орсон буюу орлого арай илүү төлөвлөгдсөн гэж үзэж байна.
						Бусад	596.6	Эх үүсвэр бага
12	Сайхан овоо	14,360.0	12,441.0	(1,919.0)	-13%	Улсын тэмдэгтийн	571.7	Эх үүсвэр бага
						Хог хаягдлын үйлчилгээ	571.0	2014 оны Аймгийн иргэдийн хурлаас баталсан 55-р тогтоолын дагуу сумдын засаг дарга нарт үүрэг болгосон боловч биелээгүй
						Түгээмэл тархац	692.1	Тус суманд лицензтэй тогтмол үйл ажиллагаа явуулдаг байгууллага байдаггүй.
						Хүү торгууль	1,115.7	Эх үүсвэр бага
						Бусад	300.4	Эх үүсвэр бага
13	Эрдэнэдалай	42472.0	47514.7	5,042.7	12%			Тасарсан орлого байхгүй

14	Сайнцагаан	161392.0	222,394.5	61,002.5	38%	Жишиг	698.3	2014 оны Аймгийн иргэдийн хурлаас баталсан 55-р тогтоолын дагуу сумдын засаг дарга нарт үүрэг болгосон боловч биелээгүй Төлөвлөх боломжгүй орлого тасарсан орлого байхгүй
						Патент	2,629.7	
						Хог хаягдлын үйлчилгээ	37,278.9	
						Хүү торгууль	1,485.4	
15	Адаацаг	24,512.0	46,821.0	22,309.0	91%			
16	Төрийн сан	3,576,824.2	4,037,528.0	460,703.8	13%	Газрын төлбөр	19.8	
						Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	72.7	
						Замын хураамж	5.8	
						Хөрөнгө борлуулсаны орлого	64.8	
Нийт дүн		4,145,137.9	4,792,764.1	647,626.2	16%		69,242.6	

Хавсралт №3

ТУСГАЙ ШИЛЖҮҮЛГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ӨӨРИЙН ОРЛОГЫН НЭГТГЭЛ

/Мянган төгрөгөөр/								
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	(Давсан)/ Тасарсан	%	Орлого тасалсан байгууллагын нэр	Тасарсан орлогын дүн	Тасарсан орлогын шалтгаан
1	Дэлгэрцогт	1,722.2	2,744.4	(1,022.2)	59%	Эрүүл мэндийн төв	194.5	Эх үүсвэр байхгүй
2	Дэрэн	2,259.7	6,271.0	(4,011.3)	178%			Тасарсан орлого байхгүй
3	Говь-Угтаал	1,419.3	1,420.0	(0.7)	0%			Тасарсан орлого байхгүй
4	Цагаандэлгэр	1,714.9	1,472.5	242.4	-14%	Эрүүл мэндийн төв	173.1	Эх үүсвэр байхгүй
						Сургууль	70.0	Өмнө нь буудлын зориулалтаар ашиглаж байсан өрөөнд шинэ захирал нь амьдарч байгаа. Тиймээс орлого биелэхгүй тасрах нөхцөлд хүргэсэн.
5	Баянжаргалан	1,504.8	1,265.8	239.1	-16%	Эрүүл мэндийн төв	90.1	Эх үүсвэр байхгүй
						Соёлын төв	177.3	Байгууллагын дотоод үйл ажиллагаа сул,
6	Өндөршил	2,200.8	2,244.7	(43.9)	2%	Сургууль	145.0	Спорт заал, орон сууцны төлбөр дутуу орсон.
7	Гурвансайхан	1,654.9	1,666.7	(11.8)	1%		-	Тасарсан орлого байхгүй.
8	Өлзийт	1,464.3	1,464.1	0.2	0%		-	Тасарсан орлого байхгүй.
9	Хулд	2,709.0	3,532.4	(823.4)	30%		-	Тасарсан орлого байхгүй.
10	Луус	1,714.8	1,740.2	(25.4)	1%		-	Тасарсан орлого байхгүй.
11	Дэлгэрхангай	2,186.0	1,418.0	768.0	-35%	Сургууль	258.2	тодотголоор орлогын төлөвлөгөө өссөн түрээсийн орлогын 20 хувь болох 93750 төгрөгийг Дундговь аймгийн Хөрөнгө борлуулсаны орлогын дансанд зохих журмын дагуу төвлөрүүлсэн

						Эрүүл мэндийн төв	152.6	орлого олох үйлчилгээ үзүүлдэггүй байгууллагад үндэслэлгүй өөрийн орлого төлөвлөсөн байна.
						Соёлын төв	357.2	байгууллагын дотоод үйл ажиллагаа сул, тайлант хугацаанд байгууллагын удирдлага солигдсон.
12	Сайхан овоо	2,798.4	2,651.0	147.4	-5%	Соёлын төв	147.4	ИТХ-аас баталсан үнэ тариф бага байгаатай холбоотой
13	Эрдэнэдалай	5,760.4	3,714.0	2,046.5	-36%		-	Тасарсан орлого байхгүй
14	Сайнцагаан	70,196.1	62,665.9	7,530.2	-11%	4-р сургууль	8,019.5	Сургалтын төлбөрийн орлого дутуу
15	Адаацаг	3,846.6	4,614.9	(768.3)	20%		-	Тасарсан орлого байхгүй
16	Биеийн тамир, спортын хороо	4,658.2	4,957.1	(298.9)	6%			Тасарсан орлого байхгүй
17	Орон нутгийн музей	2,934.4	2,933.9	0.5	0%		-	Тасарсан орлого байхгүй
18	Орон нутгийн номын сан	248.9	248.9	-	0%		-	Тасарсан орлого байхгүй
19	Төв халхын дуулалт жүжгийн театр	35,000.0	35,773.8	(773.8)	2%			Тасарсан орлого байхгүй
20	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр	4,887.5	4,926.5	(39.0)	1%		-	Тасарсан орлого байхгүй
Нийт дүн		150,881.2	147,725.7	3,155.5			9,784.9	